## ХУРАЛДААНЫ ТОЙМ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
## 2016 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны нэгдүгээр сарын 28-ны 14 цаг 06 минутад эхэлж, 14 цаг 16 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 10 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Төрийн албаны зөвлөлийн Дархан уул аймаг дахь Салбар зөвлөлийн даргыг томилох тухай | Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, “Ц.Сүхбаатарыг ажилд томилох тухай” Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны Б/01 захирамж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Цэрэнгийн Сүхбаатарыг 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн даргаар томилох<br>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 7-ын “.....Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Чулуунбатын Чүлтэмбат” гэснийг хүчингүй болгох<br>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Ц.Сүхбаатарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**